



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГазар

2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд тус парк 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд:

- Монгол улсын Засгийн газрын тогтоол - 2
- Нийслэлийн Засаг даргын захирамж – 4
- Нийслэлийн дотоод аудитын тогтоол – 1
- Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл – 3
- Төрийн болон бусад байгууллагаас нийт 206 албан бичиг ирснээс хариутай албан бичиг нь 79 байж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагаас бусад байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 240 албан бичиг явуулсан.

Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд паркийн 120 га газар дээр байгуулах 2 ширхэг гүний худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж дууссан. 2 худгийн барилгын ажил хийгдэж байна. “ТТТ” ХХК-руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил хийгдсэн.

**НЭГ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО: 3.2
ХОТЫГ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН ТӨВ БОЛГОН ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

- 1.1. Цэвэрлэх байгууламж барих хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох яамд, тамгын газарт хүсэлт гаргах, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж хүргүүлэх
- Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгжээр дамжин хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд “Европын сэргэн босголт, хөгжлийн банк”-ны санхүүжилтээр санхүүжүүлэхээр бичиг баримтын бүрдлийн ханган хүргүүлсэн.
- 1.2. Паркийн дулааны станц, бусад дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.
- 26 МВт-ийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг барилга хот байгуулалтын яамны 2023 оны төсвөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна.

**ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН
ЗОРИЛГО: 6.2. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ
НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ УЯЛДУУЛЖ, ХҮН АМЫН
НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ БҮС, ОРОН
НУТГИЙН ХӨГЖЛИЙН УЯЛДААГ ХАНГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:**

- 2.1. БМБХТөвийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.
- “Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв” байгуулах төслийг НБМҮТП-г түшиглэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах Тогтоол, захирамжийн хүрээнд 60 га талбайд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болосвруулах ажлын хөрөнгө оруулалтын санал болон зураг төсөл гүйцэтгүүлэх саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.

**ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН
ЗОРИЛГО: 4.1. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН УХААЛАГ ШИЙДЛҮҮДИЙГ АШИГЛАН
ХОТЫН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ, НЭЭЛТТЭЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ
ХҮРГЭДЭГ УХААЛАГ ХОТЫГ БИЙ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

3.1. Арга хэмжээ 1: 4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

- Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын хүрээнд байгууллагаас гаргасан аливаа тушаал, шийдвэр, гэрээ хэлцэл, төсөв хөрөнгө захиран зарцуулах болон байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, санхүүгийн тайлан мэдээ, орлого, зарлага, санхүүжилт, өндөр дүнтэй гүйлгээ зэрэг бүх мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан. Хагас жилийн байдлаар нийт 20 төрлийн мэдээг сар бүр мэдээллэсэн.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

4.1. 110/10 кВ-ын 2х16 мВА чадалтай дэд станцын угсралтын ажлыг бүрэн дуусгах ажилд хяналт тавих.

- Үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2022 онд нийслэлийн төсвөөс 3,578,2 сая төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 1,000,0 сая төгрөг нь хасагдан 1,500 сая төгрөгийг урьд онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилтэд суутгагдсан. Үлдэгдэл 580,8 сая төгрөгөөр Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч “Вилл вест” ХХК нь 110/10 кВ-ын дэд станцын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн тоног төхөөрөмжийн суурь, 10 кВ-ын 13,8 км кабель шугамын угсралтын ажлыг бүрэн дуусгасан ба “10 кВ-ын хуваарилах байгууламж”-ийн тоног төхөөрөмж, материалын захиалгыг хийж урьдчилгаа төлбөрөө төлсөн боловч төлбөрөө бүрэн хийх хөрөнгийн эх үүсвэргүйн улмаас татан авалтын ажил зогссон.

4.2. 110 кВ-ын ЦДАШ-ын Барилга угсралтын ажлыг эхлүүлэх

- Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүсэлтийг НЗДТГ-т хүргүүлсэн бөгөөд 2022 оны төсвийн тодотголоор үндсэн цахилгаан хангамжийн санхүүжилт хасагдан бүтээн байгуулалт хийгдээгүй.

4.3. Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах.

- 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 37 аж ахуйн нэгж паркт байрших хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн төсөл, байгаль орчинд ээлтэй, хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, шинэ технологийн талаарх мэдээллийг судалж дүгнэлтийг гарган 26 аж ахуйн нэгжтэй шинээр хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 6 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулах гэрээг сунган ажиллаж байна.

4.4. Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, хяналт үнэлгээ хийнэ.

- Паркийн 250 га газар дээр нийт 50 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 46 аж ахуйн нэгжтэй гэрээ дүгнэн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бичиг баримт, зураг төслийн бүрдлийг хангах шаардлага

хүргүүлсэн. 10 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 2 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд Налайх дүүргээс 18 иргэнийг түр ажлын байраар ханган, барилга угсралтын ажил 30%-тай явагдаж байна. 5 аж ахуйн нэгжид үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай цахилгаан хангамжийн түр тэжээлээр хангаад байна.

4.5. Паркийн цэвэр ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж, УДДТ-үүдийн барилга байгууламжуудийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийг хийлгэх хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох газруудаар шийдвэрлүүлэх.

- Паркийн дэд бүтцийн барилга, байгууламжуудийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ, БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргасан.

4.6. Паркийн 250га талбайд техник технологийн түвшний ерөнхий үнэлгээ хийлгэх.

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь хэсгийн дагуу техник технологийн түвшний үнэлгээг боловсруулах 45 сая төгрөгийн төсвийг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх зураг төслийн саналд хүргүүлсэн боловч хөрөнгө оруулалт тусгагдаагүй. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдан 2022.08.01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх болсонтой холбоотойгоор техник технологийн түвшиний үнэлгээг хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын дагуу боловсруулахаар болсон.

4.7. Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэвийн тасралтгүй явуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж өглөг авлагагүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

- Санхүүгийн тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бүртгэж хөтлөх, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бодитой тайлагнаж байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж нөхцөлөөр ханган анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг бэлтгэн ажиллаж байна. Шинээр өр төлбөр үүсээгүй.

4.8. Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын сайт, цахим хуудсуудад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол тавьж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа хийх.

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:

- Үйл ажиллагааны ил тод байдал,
- Хүний нөөцийн ил тод байдал,
- Төсөв, санхүүгийн ил тод байдал,
- Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна.

4.9. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаархи мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.

- Гадаад томилолт – 1,
 - Зочид төлөөлөгчид – 5,
 - Албан уулзалт – 4,
 - Олон улсын цахим хурал – 1,
 - Гэрээ, санамж бичиг – 1 тус тус хийгдэж, тухай бүрт нь байгууллагын үйл ажиллагааны болон, шаардлагатай хөрөнгө оруулалт, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллийг танилцуулж, хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж ажилласан.
 - БНХАУ, БНСУ, ХБНГУлсуудын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчидтэй түлхүү холбогдож ажиллалаа.
- 2022.01.03-нд БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Монгол Авто Ресайкл Парк” ХХК-д гэрээнд заагдсан нөхцлийг гүйцэтгээгүй, паркийн зүгээс тавьсан шаардлага болон гэрээний тодорхой заалтуудыг биелүүлээгүй, гэрээний хугацаа дуусгавар болж байгааг үндэслэн гэрээг цаашид сунгах боломжгүй талаар албан бичиг боловсруулан хүргүүлсэн.
 - 2022.01.20-нд БНСУ-ын JNP Bio Co.Ltd-ийн хүсэлтээр паркийн хүсэл зоригийн захиа буюу LOI /Letter of Intent/-ийг боловсруулан Монгол болон Солонгос хэл дээр хүргүүлсэн. Мөн тус компанийн хүсэлтээр паркийн үйл ажиллагааны мэдээлэл болон дэд бүтцийн ажлуудын танилцуулга хүргүүлсэн. Улмаар 2 дугаар сард тус компанийн удирдлагуудтай уулзалт зөвлөгөөн хийхээр товлогдсон.
 - 2022.01.25-нд “Монгол авто ресайкл парк” ХХК-ийн ТУЗ хуралдаж гүйцэтгэх захирал шинээр томилсон тухай, шинэ томилогдсон гүйцэтгэх захирал паркийн үйл ажиллагаатай танилцах, цаашид үйл ажиллагаа явуулах гэрээгээ сунгах талаар уулзалт хийсэн. Тус уулзалтанд “Монгол авто ресайкл парк” ХХК-ийн хуучин гүйцэтгэх захирал оролцсон. Тус



компани нь гэрээгээр хүлээсэн зарим зүйл заалтыг биелүүлээгүй, үйлдвэрлэлийн барилга байгууламж баригдах ажил хийгдээгүй, Корона вирусийн тархалтаас шалтгаалан хөрөнгө оруулалт хийх, ажил эхлэх боломжгүй байсан гэх шалтгийг 3 жилийн хугацаанд хэлж ирсэн учраас паркийн зүгээс дахин гэрээг сунгах боломжгүй гэж мэдэгдсэн.

- 2022.02.16-нд Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатар ажлаа хүлээн авч үйлдвэр технологийн паркуудтай танилцах, мэдээлэл авах, ажлын явцтай танилцахаар паркад айлчилсан. Уг



айлчлалын хүрээнд шинээр томилогдсон орлогч Б.Сүхбаатар дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд дээр зөвхөн улс, нийслэлийн хөрөнгө оруулалтыг хүлээлгүйгээр төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэж болох арга замуудыг судалж, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж болох талаар санал зөвлөмж өгсөн.


- 2022.02.16-нд Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн паркийн дарга шинээр томилогдсонтой холбогдуулан манай паркад айлчилж, паркийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, цаашид байнгын холбоотой хамтран ажиллах талаар уулзалт зөвлөгөөн хийсэн. Шинээр томилогдсон дарга Б.Мягмар, үйлдвэрлэл технологийн албаны дарга А.Анхзаяа, үйлдвэрлэл технологи хариуцсан мэргэжилтэн Б.Батболд нар хүрэлцэн парктай танилцсан.



- 2022.02.18-нд Бүгд Найрамдах Солонгос Улсын “JNP Bio Co.Ltd”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Пак Чол Жүн паркад айлчилж паркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцсан. Тус компани нь Солонгос улсын барилгын материалын үйлдвэрүүдийн салбарыг паркад байгуулах хүсэлтэйгээ илэрхийлж цаашид хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцсон. Орон сууцны домофон системийн төхөөрөмжийн үйлдвэр, будгийн үйлдвэрүүдийг танилцуулж паркад байршин үйлдвэрлэл явуулах, монгол улсын хэрэгцээг хангахын зэрэгцээ ОХУ руу ч мөн бүтээгдэхүүнээ гарган борлуулах боломжтой эсэхийг сонирхсон. Улмаар хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар харилцан тохиролцсон.



- 2022.02.21-ны өдөр Монгол Улсын шадар сайд С.Амарсайхан, Нийслэлийн барилга, орон сууц, үйлдвэр технологийн парк хариуцсан орлогч Б.Сүхбаатар, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Нийслэлийн засаг даргын зөвлөх Б.Нэргүй, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн удирдагч Д.Авирмэд болон Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн дарга С.Батжаргал нар Паркийн дэд бүтцийн ажлын явц болон хөрөнгө оруулалтын талаар уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар Паркт нэн даруй шаардлагатай дэд бүтцийн ажлуудын талаар хэлэлцэж, Шадар сайд С.Амарсайханы зүгээс бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.



- 2022.02.22-ны өдөр БНСУ-ын “JNP Bio Co Ltd”-ээс ирүүлсэн паркад холбогдох асуултууд бүхий 5 бүлэг, нийт 45 асуултыг Солонгос хэлнээс орчуулан удирдлагад танилцуулсан. Уг асуултуудад хариулт бэлтгэж Солонгос хэл рүү хөрвүүлэн хүргүүлсэн.
- 2022.02.25-ны өдөр “100 айл”-ыг нүүлгэн шилжүүлэх талаар судлах ажлын хэсэг хуралдаж, 100 айлыг нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөсөн “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн одоогийн нөхцөл байдлын талаар мэдээллийг сонсож, цаашид зохион байгуулах ажлын талаар хэлэлцлээ. “Налайхын барилгын материалын

үйлдвэрлэл, технологийн парк"-ийн дэд бүтцийн ажилд шаардлагатай төсвийг шийдвэрлэхээр ажиллана гэдгийг ажлын хэсгийн ахлагч Г.Төгөлдөр онцолж байсан бөгөөд зөвхөн улс, нийслэлийн төсөвт найдах бус, олон улсын хөрөнгө оруулалтын байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжуудыг эрэлхийлэх хэрэгтэйг илэрхийлсэн.



- 2022.03.04-ны өдөр “Монгол Авто Ресайкл Парк” ХХК-ийн хуучин удирдлагын хүсэлтээр тус компанид хүргүүлж байсан албан бичгүүдийн хуулбарыг хүргүүлсэн.
- 2022.03.14-ны өдөр Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх “НЭГДҮГЭЭРТ ШАЛГА” арга хэмжээний хүрээнд байгууллагын ажилтан албан хаагчид гэрээсээ сургууль хүрэх орчны хүүхдийн аюулгүй байдалд үнэлгээ хийсэн. Үнэлгээ хийх явцад 4 төрлийн зөрчлийг илрүүлсэн. Хүүхдийнхээ аюулгүй байдалд анхаарлаа хандуулж орчин бүрийг үнэлж, эрсдлээс хүүхдээ хамгаалцгаая.
- НЗД-ын орлогч Б.Сүхбаатар туршлага судлах, очиж үзэх, ижил төстэй паркуудын судалгаа гаргаж өгөх үүрэг даалгаврын дагуу 2 паркийн мэдээлэл орчуулан бэлтгэж хүргүүлсэн. Уг үүрэг даалгаврын хүрээнд Багахангай, Багануурын ҮТП-ийн гадаад харилцааны мэргэжилтнүүдтэй холбогдож мэдээлэл солилцон, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар ярилцсан.
- НЗДТГ-ын Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв болон Азийн сангийн Хотын засаглалыг сайжруулах төслөөс санаачлан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудан албан хаагчдын дунд 4 дүгээр сарын 13-наас 5 дугаар сарын 10-нд хооронд зохион байгуулсан “Нийслэл-110” менторшип хөтөлбөрийн 1 дүгээр шатанд хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь мэдлэг туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн төрийн албан хаагч өөрийн мэдлэг, туршлагаа шинээр томилогдсон албан хаагчтай хуваалцах, тэднийг чиг үүргээ үр нөлөөтэй, бүтээмжтэй хэрэгжүүлэхэд зөв чиглүүлэх, туслах замаар мэдлэг, мэргэшил, ур чадварыг нь нэмэгдүүлэхэд оршино. Тус хөтөлбөрт хамрагдаж нийт 6 удаагийн идэвхижүүлэх уулзалтанд оролцсон. Мөн хуваарилагдсан багийн гишүүдийн хамт “ТӨР ОЙРХОН” бичил төслийг санаачлан боловсруулан хэрэгжүүлсэн.
- 2022.04.07-ны өдөр Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан Улаанбаатар групп ХХК-ийн захирал, төлөөлөгчид паркт ирж дэд бүтцийн ажлын явцтай танилцаж, үйлдвэр

барих газрын байршил дээрээ ажилласан. Тус компани нь паркийн газарт жилд 3000 айлын орон сууц барих хүчин чадал бүхий бетон эдлэлийн цогц үйлдвэр барихаар төслөө танилцуулсан.



- 2022.04.28-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын “V World Korea” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Су Ён Сүк, Мүн Жэ Хва тэргүүтэй төлөөлөгчид паркт айлчлан паркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажилтай танилцсан. Гүйцэтгэх захирал Су Ён Сук нь Паркийн дулааны цахилгаан станцын төсөл дээр хамтарч ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Паркийн газар дээр 10000мВ-ын хүчин чадал бүхий, нүүрсийг 1300 градуст халааж, цахилгаан, дулаан, газ үйлдвэрлэх станц барих төсөл танилцуулсан.

- 2022.04.29-ний өдөр Налайхын их уурхай, дүүргийн 100 жилийн ой, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын нэрэмжит уламжлалт “Үндэсний бичиг мину” уралдаан дүүргийн 56 албан байгууллагын 112 ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан бөгөөд уг тэмцээнд НБМҮТ Паркийг төлөөлж, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Т.Тэлмэн, Нярав Э.Ундармаа нар амжилттай оролцож, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Т.Тэлмэн тусгай байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн байна.



- 2022.05.14-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, иргэдэд мод тарих соёлыг сурталчилан түгээх ажлын хүрээнд “Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Ногоон хот-Иргэний оролцоо” мод тарих арга хэмжээний нээлт өнөөдөр зохион байгуулагдлаа.

Нээлтийн үйл ажиллагаанд Улсын их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан, Гадаад харилцааны сайд С.Батцэцэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч С.Нэргүй, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

П.Нарантуяа, болон бусад яам, агентлаг элчин сайдын газарууд, дүүргийн харьяа байгууллагын дарга, ажилтан, алба хаагч нар оролцлоо.

Манай байгууллага өмнөх онд тарьсан мод сөөгний арчилгаа, тордолтыг хийж, энэ онд тарих модоо суулган, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ажлыг эхлүүлээ.



- 2022.05.17-ны өдөр Паркийн дарга С.Батжаргал тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын “China Conch Venture Holdings Ltd”-ийн удирдагуудтай цахим хурал хийсэн. Цахим хурлаар тус компанийн танилцуулга, Улаанбаатар хот дахь хог хаягдал боловсруулах төслийн танилцуулгууд хийгдэж, талууд Улаанбаатар хот дахь хог хаягдал дахин боловсруулах төслийн талаар ярилцаж, санал дүгнэлт өгч, дараагийн ажлын төлөвлөгөөг ярилцсан.
- 2022.05.18-ны өдөр Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас зохион байгуулж байгаа Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн байршилтай танилцах аяллын хэсэг Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркттай танилцсан. Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа – 2050”-д Улаанбаатар хот орчимд 15 дагуул хот байгуулахаар төлөвлөснөөс эхний ээлжинд байгуулах боломжтой 5 дагуул хотын газар дээр очиж нөхцөл байдалтай танилцах, холбогдох байгууллагуудтай нэгдсэн ойлголтод хүрэх, дагуул хот, эдийн засгийн тусгай бүм байгуулах талаар хийж хэрэгжүүлэх ажлыг танилцуулах, цаашид хамтран ажиллах чиглэл, зорилгыг тодорхойлоход тус аялалын зорилго оршиж байсан.



- 2022.05.19-ний өдөр Монгол улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд хуваарийн Налайхын зүүн чиглэлийн автозамын А/24 постноос Хөнгөн блокны үйлдвэр хүртэл зам дагуу 130 ширхэг хайлаас, 10 ширхэг улиас модны суулгацыг тарьж усалгаа арчилгааг хийн цэцэрлэгжүүлэлтийн албанд хүлээлгэн өгсөн.



- 2022.05.24-нд “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-ын хүрээнд НЗДТГ-ын Гадаад харилцаа хамтын ажиллагааны газарт байгууллагын 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн гадаад хамтын ажиллагааны тайланг зохих загварын дагуу гаргаж хавсралтуудын хамт хүргүүлсэн.

- 2022.06.15-ны өдөр Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн дарга С.Батжаргал тэргүүтэй 6 албан хаагчид “V World Korea” ХХК-ийн албан урилгаар БНСУ-д айлчилж тус компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлтэй танилцах, туршлага судлах, ижил төстэй үйлдвэрлэл технологийн паркийг үзэж сонирхохоор Монгол дахь БНСУ-ын консулын хэлтсээс виз хүссэн. Визний материалын бүрдүүлэлт хийн, Чингис Жоней төлөөлөн гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгсөн. БХБЯамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнгийн дэмжлэгтэйгээр ГХЯамнаас Ноот бичиг хүсэн гаргуулан авч визний материалд хавсаргасан.



- 2022.08.02-ны өдөр БНСУ-ын Дэгү хотын Менежмент удирдлагын холбооны захирал Ким Ир Вон, Монгол Солонгосын соёл эдийн засгийн төвийн дарга Нам Сан Дэ, "Жа-Ин" мал эмнэлгийн дарга Пак Пен Юн, "Самхуа пластик" ХХК-ын ерөнхий захирал Ян Сог Хун, Солонгосын зээлийн батлан даалтын сангийн хэлтсийн дарга И Сан Ил, "Рутос Кореа ХХК"

хэлтсийн дарга И Сүн Хон, Бизнес, хөрөнгө оруулалт, IPO хариуцсан захирал Жан Ён Чэ тэргүүтэй хөрөнгө оруулагчид НБМҮТПарктай ирж танилцлаа.

Паркийн дарга С.Батжаргал Паркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажлуудыг танилцуулсан бөгөөд Үйлдвэрлэл технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар хамтран ажиллах ААН-үүдэд хууль эрхзүйн талаасаа олон давуу тал бий болсныг онцолсон.



- 2022.08.05-ны өдөр БНСУ-ын "KoreaTop" группын захирал Юн Мён Сун Паркийн үйл ажиллагаа, дэд бүтцийн мэдээлэлтэй танилцлаа.

Тус групп нь БНСУ-д цэвэрлэх байгууламж барьж, ашиглалтад оруулж байсан туршлагатай бөгөөд Паркийн цэвэрлэх байгууламжид хөрөнгө оруулалт хийх боломжийг судалж байгаа бөгөөд Паркийн цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, талбай, үндсэн тоноглол, нийт хөрөнгө оруулалт зэрэг дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцаж, цэвэрлэх байгууламж барих газар дээр очиж судласан бөгөөд цаашид хамтран ажиллахаа илэрхийлсэн.



- 2022.08.15- 22-ны өдрүүдэд НБМҮТПаркийн удирдлага болон инженерүүд дэлхийн улс орнуудад жишиг болсон БНСУ-ын томоохон үйлдвэрлэгч байгуулагуудын үйлдвэрлэл, шинэ дэвшилтэт техник технологитой танилцах, туршлага судлах, үйлдвэрлэлийн процессыг газар дээр нь үзэх, паркад нутагшуулж болохуйц үйлдвэрлэлийг татан оруулж ирэх, гэрээ байгуулсан БНСУ-ын хөрөнгө оруулалт бүхий компанийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах зорилго бүхий айлчлалыг зохион байгууллаа.

Тус ажлын айлчлалаар "V World Korea", "Дүүсан эрчим хүч", "Sungsin metal industrial", "JNP BIO" ХХК болон БНСУ-ын хөрөнгө оруулалттай "Мөнх Майнинг" ХХК зэрэг ААН, үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцлоо.

“V World Korea” Co.,Ltd нь 2005 онд “KM барилга” нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан бөгөөд 2019 онд “V World Korea” ХХК болон нэрээ өөрчлөн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Тус компани нь уур амьсгал, байгаль орчны өөрчлөлтөөс шалтгаалсан НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн конвенцид түшиглэсэн үйл ажиллагаа явуулах, дотоодын байгаль орчны нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн бүтээн байгуулалт, холбогдох төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компани юм. Газын хоолойн үйлдвэрлэл, барилгын технологид тулгуурлан Монгол орны агаарын орчныг сайжруулахын тулд хамгийн шилдэг технологи, туршлагаар газын хоолойн төсөлдөө цагираг хэлбэрийн холболтын аргыг боловсруулсан. Тав тухтай орчныг бүрдүүлэхийн тулд Монгол улсын байгалийн хийн хоолойн төслийн эдийн засгийн баталгааг хангах, барилгын ажлын хугацааг богиносгох зорилгоор тогтвортой, чанараа алдахгүй бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлнэ. Дэлхийн хамгийн шилдэгт тооцогдох технологи болон чанарыг хангаж илүү олон технологийг хөгжүүлэх болно. Ирээдүйд улс орон бүрийн нөхцөл байдлыг харгалзан технологийн тасралтгүй хөгжлийг туршиж, үүн дээр тулгуурлан хамтдаа хөгжиж явна гэсэн үндсэн зорилгоор Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркттай хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлж өөрийн компани болон хамтран ажиллагч байгууллагуудаа танилцуулахаар паркийн удирдлага, албан хаагчдыг урин хүлээн авсан.

Дүүсан эрчим хүч нь 1962 онд үүсэн байгуулагдсан машины тоног төхөөрөмж үйлдвэрлэгч дэлхийн томоохон компаниудын нэг юм. Тус компани нь одоогийн байдлаар 4 төрлийн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа бөгөөд үүнд:

- Хийн турбины үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, эд анги
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, эд анги
- Устөрөгчийн эрчим хүчний
- Жижиг модульчлагдсан реакторууд /Дараагийн үе болох цөмийн цахилгаан станц/ багтдаг.

Мөн өдөр Сөүл хотоос 58 км-ийн зайд орших Гимпо хотод баригдаж буй Сөүл хот, Гёнги аймгийн баруун бүсийг дулаан эрчим хүчээр хангах Дүүсан эрчим хүч группийн хэрэгжүүлж буй 500мб-ийн хүчин чадал бүхий газан дулааны станцын барилга угсралтын ажилтай танилцсан.

Сөүл хотоос 210 км зайд Чүнчоннам аймгийн Гимсан хотод байрлах Sungsin metal industrial ХХК-д зочилж үйлдвэрлэлийн процесстой танилцсан. Тус компани нь 1990 онд үүсгэн байгуулагдсан жилд 7800 тонн төмрийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, БНСУ-даа дээгүүр ордог ган цутгамал бүтээгдэхүүний үйлдвэр юм. Голчлон ган цутгамал бүтээгдэхүүн, усан онгоцны эд анги, үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн эд анги, төмөр замын эд ангийг үйлдвэрлэдэг. БНСУ-ын Хьюндай, Поско, Флутек, Японы Мицубиши үйлдвэрүүдэд тоног төхөөрөмж болон автомашины эд ангиудыг нийлүүлдэг. БНСУ, Япон, АНУ, Хятад, Итали зэрэг орнуудад бүтээгдэхүүний дээжээ хүргүүлэн баталгаажсан сертификатыг авсан байна.

Парктай гэрээ байгуулан ажиллаж буй БНСУ-ын хөрөнгө оруулалттай “Мөнх Майнинг” ХХК-ийн удирдлага, үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчтай уулзаж тус компанийн цаашдын төлөвлөлт, Солонгос дахь үйл ажиллагааны явцтай танилцаж, мэдээлэл авсан. Мөн хөрөнгө оруулалтаа хурдан шийдэж үйлдвэрлэлийн барилгын ажлаа хийх, цаашлаад үйлдвэрлэлээ хурдан эхлүүлэх шаардлагыг тавьсан.

Паркад үйл ажиллагаа явуулах, паркийн нэгжээр элсэх хүсэлтээ 3 дугаар сард ирүүлсэн “JNP BIO” Co.,Ltd компанийн ТУЗ-ын дарга Пак Чол Жүн-тэй уулзалт хийсэн. Тус компанийн удирдлагууд 9 дүгээр сард Монгол Улсад ирэхдээ компанийнхаа үйл ажиллагааны танилцуулга, паркт байгуулах хүсэлтэй байгаа будгийн үйлдвэрийн төслийг дахин танилцуулахаар ярилцаж тохирсон.



- 2022.09.10-ны өдөр НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас зохион байгуулж буй “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй өдөрлөгт Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх төрлөөр оролцож иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны талаар танилцуулсан.



- 2022.09.30-ны өдөр “УЛААНБААТАР БҮК” ХК-тай хамтран ажиллах уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтад УБ БҮК ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Мөнхөө, ТУЗ-ийн гишүүн Громов Сергей Борисович Налайхын барилгын материал үйлдвэрлэл технологийн паркийн дарга С.Батжаргал, ахлах Н.Пүрэвсүрэн, ерөнхий инженер Б.Батбилэг нар оролцсон бөгөөд уулзалтаар паркийн дэд бүтцийн нэг болох 10,2 км урттай төмөр замын ажил дээр хамтран ажиллах боломжтойг илэрхийллээ.

Паркад металл хийц эдлэл боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулснаар сардаа 1000тн төмөр хийц эдлэл үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд том оврын хүнд жин бүхий хийц үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийг цех рүү оруулах, бэлдцийг технологийн дамжлагын машин хооронд шилжүүлэх, нарийвчилсан хэмжилт тэмдэглэгээ, зүсэлт хийх, нэгтгэх, гагнах, өрөмдөх буюу технологийн болон бэхэлгээний нүх гаргах, марклах, гадаргуун өнгөлгөө будаг хийх зэрэг боловсруулалтын ажилбаруудыг гүйцэтгэх, хадгалалт, тээвэрлэлтэд ачих, буулгах зэрэг технологийн бүх шат дамжлагад шаардлагатай нөхцөл бүрдүүлэн ажиллах боломжтой. Ингэснээр бид төмөр каркасан барилга, төмөр гүүр, гүүрэн краны зам, цахилгаан дамжуулах шугамын ган тулгуур, зэрэг том оврын төмөр хийц эдлэлийг чанарын өндөр төвшинд үйлдвэрлэнэ.



- 2022.11.25-ны өдөр Эмээл эко аж үйлдвэрийн парк НӨААТҮГ-ын ажилтнууд Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн паркийн үйл ажиллагаатай танилцлаа. Ерөнхий инженер Б.Батбилэг паркийн үйл ажиллагаагаа танилцуулж, цаашдаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэн холбоотой ажиллах талаар санал солилцлоо.




- 2022.11.29-ний өдөр Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Германы хамтын ажиллагааны байгууллага хамтран Европын холбооны санхүүжилттэй "Эрчим хүчний зохистой шилжилт" төслийг танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад "Налайхын дулааны Станц" ТӨХК, "УБЦТС" ХК-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төв, "УБЦТС" ХК-ийн Түгээх төв, Таван толгой түлш ХХК, Налайхын Барилгын материал, үйлдвэрлэл, технологийн парк, Эрчим хүчний үндэсний төв зэрэг байгууллагуудын удирдлагууд, инженерүүд, уурхайчдын төлөөлөл, дүүргийн удирдлагууд, "IKI JET" төслийн ахлах мэргэжилтэн Ларс Блюм, төслийн зөвлөх С.Цэрэндаш нар оролцлоо. Талууд уулзалтын үеэр "IKI JET" төслийн талаар ойголтыг авч, нүүрсний эрчим хүчнээс сэргээгдэх эрчим хүчид шилжих төслийг дүүрэгт хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцсон юм.



- 2022.12.05-ны өдөр Германы хамтын ажиллагааны байгууллагын "Эрчим хүчний зохистой шилжилт" төслийн ахлах мэргэжилтэн Ларс Блюм, төслийн зөвлөх С.Цэрэндаш нар НБМҮТПарктай ирж танилцлаа.

Уг төсөл нь Европын холбооны санхүүжилтээр явагдаж байгаа бөгөөд нүүрс ашиглаж эрчим хүч үйлдвэрлэхээс бага багаар татгалзаж, сэргээгдэх эрчим хүч ашиглахаар зорьж буй улс орнуудын орон нутгийн удирдлага, холбоод, байгууллагуудад зохистой, хохиролгүй, үр дүнтэй шилжилт хийхэд нь зөвлөгөө, аргазүйн тусламж үзүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа явуулах юм.

Дээрх уулзалтаар Паркийн зорилго, үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, цаашид хийгдэхээр төлөвлөж буй ажлуудыг танилцуулсан бөгөөд тус Парк бүрэн ашиглалтад орсноор Налайх дүүргийн ажилгүйдэл буурахад томоохон нөлөө үзүүлнэ гэдгийг Паркийн дарга С.Батжаргал онцоллоо. Хоёр тал цаашид хамтран ажиллахаар тохирсон.



4.10. Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй, албан бичгийн норм стандартыг мөрдөх, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

- Эдок системд жилийн эцсийн байдлаар албан хаагчдаас гаргасан зөрчил байхгүй бөгөөд албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 4,5 байна. Шинэчлэгдэн гарсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу баримт бичгийг боловсруулан ажиллаж байна.

4.11. Иргэд, албан хаагчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээ тайланг НЗДТГ-т хүргүүлэх.

- Иргэдээс ирүүлсэн 2, албан хаагчдаас ирүүлсэн 23 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, тайлан мэдээг улирал бүр НЗДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлж байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног 5 өдөр. Шийдвэрлэлтийн тайлан, мэдээг байгууллагын даргын дэргэдэх байнгын зөвлөлийн хуралд танилцуулан ажилласан.

4.12. Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивт бүрдүүлэлт хийх.

- Байгууллагын архивын төлөвлөгөө, архивт баримт хүлээн авах хуваарь, 2022 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлан хуваарийн дагуу албан хаагчдаас цаасан болон тусгай төрлийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэлийг шинэчлэн үйлдсэн. Архивын өрөөний чийгшил, цэвэрлэгээ үйлчилгээ, түр олгосон баримтын бүртгэл, хуулбар олгосон баримтын бүртгэл зэрэг шаардлагатай бүх бүртгэлийг тухай бүр нь хөтөлж байна. Мөн газрын даргын 2021 оны захирамжлалын цахим баримтыг архивын дэд системд бүртгэн нийслэлийн Архивын газарт цахим тээгчид буулган хүлээлгэн өгсөн. 2023 онд төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу бэлтгэл байдлыг хангасан.

4.13. Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, болон хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж батлан мөрдөж ажиллах.

- Хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, хөдөлмөрийн гэрээний холбогдох зүйл заалтад өөрчлөлт оруулан албан хаагчидтай байгуулсан.

4.14. Албан хаагчдыг чадавхижуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах.

- Дүүрэг, нийслэл болон холбогдох газруудаас зохион байгуулсан 12 сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан

- НД-ийн Татварын хэлтэс-Хөрөнгө орлогын мэдүүлэг – 12 албан хаагч
- НЗДТГ- Нийслэл RISE-Academy сургалт – 1
- НД-ийн Цэцэрлэгжүүлэлтийн алба – Агротехникийн мэдлэг олгох сургалт – 2
- НБИХГ-Төр хувийн хэвшлийн түншлэл сургалт, хэлэлцүүлэг – 5
- НАГ- Албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмыг танилцуулах сургалт – 1

- НАГ- Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагуудад чиглэл олгох сургалт – 1
- НӨХГ –Төрийн өмчийн тооллогын системийн сургалт – 2
- НЗДТГ- Нийслэл 110 Менторшип хөтөлбөр – 1
- НЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс-Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын тухай – 2
- НАГ-Шинээр томилогдсон албан хаагчдад ААХХ-ийн мэдлэг олгох сургалт – 2
- НЗДТГ, “Легал линк си би эй”-FIDIC-ийн жишиг гэрээ, түүний онцлог сургалт – 1
- НЗДТГ, Удирдлагын академи–Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах нь сургалт – 1
- НЗДТГ-ын Хөгжүлийн бодлого, төлөвлөлтөлийн хэлтэс-"Улс, нийслэлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан бичиг баримт боловсруулах нь" сэдэвт сургалт -1

Нийслэл дэх Жендерийн салбар хороо – “Жендэр ба хүний эрх” сургалт – 1

НЗДТГ – “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх” сургалт – 2

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газар - Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд боловсруулсан эрх зүйн баримт бичиг, шинэчилсэн стандартыг танилцуулах, Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад мэдээлэл өгөх, хэвлэмэл хуудас ашиглах заавар, зөвлөгөө – 1

НЗДТГ – “HR-2022” чуулга – 1Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар сурталчлах, албан хаагчдад мэдээлэл өгөх, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.

Дотоод сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд:

- Албан бичиг, тайлан, төлөвлөгөө, түүний биелэлт гаргах
- Эдокийн боловсруулалт цэсээр албан бичиг боловсруулах талаар зохион байгуулж давхардсан тоогоор 14 албан хаагч оролцсон.

Ажилтнуудад хууль, эрхзүйн мэдлэг олгох үүднээс "Хуулийн цаг" мэдээллийн цагийг зохион байгуулж дараах чиглэлээр 4 удаа мэдээллийг өгсөн. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль
- Үйлдвэр технологийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан өөрчлөлт орсон зүйл заалтын талаар,
- Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэрэгжүүлэх зорилго зорилтыг паркт хэрхэн уялдуулах талаар,

Төсвийн хэмнэлтийн хуулийн мэдвэл зохих зүйл заалтуудын талаар тус тус мэдээлэл хийж давхардсан тоогоор 34 албан хаагч хамрагдсан.

Дээрх сургалтуудад нийт 107 албан хаагч хамрагдсан.

4.15. Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар сурталчлах, албан хаагчдад мэдээлэл өгөх, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, тус биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргаж, холбогдох дээд байгууллагад хүргүүлж ажилласан. Тухайн жилд албан хаагчдад мэдээлэл хүргэх сургалт – 2, цахим хуудсаар сурталчилгаа мэдээлэл – 6-г хүргэж, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд ажилтан, албан хаагчдыг уриалж, оролцуулсан.

4.16. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO 45001:2018 стандартыг мөрдүүлж ажиллах.

- MNS ISO 45001 : 2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо – Шаардлага, хэрэглэх зааврыг байгууллагын хэмжээнд баримтлан ажиллаж байна. Шинэчлэгдсэн Хөдөлмөрийн гэрээний 2.3.2, 2.3.4, 2.4.3 – т хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрх, үүргийн талаар тусгасан.
- Байгууллагын ХАБЭА-н стандартыг мөрдөх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг гаргасан.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 36 хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2022 оны жилийн эцсийн байдлаар)

№	ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ**	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
<p>Бүлгийн нэр: ХОЁР ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО Зорилго: 2.6. Үндэсний бахархал, өв соёл, үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж,соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно.</p>												
11	3.7.11.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.	8.Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.	2020-2023	НЗДТГ	Улсын төсөв, Нийслэлийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	12,200.0	НБМҮТП-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулсан, 120 га талбайд үйлдвэрийн барилга байгууламжийг барих ажлыг эхлүүлсэн.	Инженерийн дэд бүтцийг барих ажлыг эхлүүлнэ.	3,577.3	2,577.3	- НБМҮТП-ийн үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2022 онд нийслэлийн төсвөөс 3,577.3 сая төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 1,000,0 сая төгрөг нь хасагдсан. Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч "Вилл вест" ХХК нь "110/10 кВ-ын дэд станцын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл"-ийн тоног төхөөрмжийн суурь, "10 кВ-ын кабель шугамын угсралт"-ын ажлыг бүрэн дуусгасан. "10 кВ-ын хуваарилах байгууламж"-ийн тоноглолын угсралт, суурилуулалтын ажил болон 1,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалын захиалга хийн татан авалтын ажлуудыг хийж байна. - 1000 м3 цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг "Европын сэргээн босголт, хөгжлийн банк"-ий санхүүжилтээр гүйцэтгүүлэх санал хүргүүлээд байна. - 26 МВт-ийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг барилга хот байгуулалтын яамны 2023 оны төсвөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна. - ҮТП-ийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ,	50

											<p>БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргасан.</p> <p>- 2022 онд парктэй гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд барилга угсралтын ажил 30%-та явагдаж байна.</p> <p>- “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд паркийн 120 га газар дээр байгуулах 2 ширхэг гүний худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж дууссан. 2 худгийн барилгын ажил хийгдэж байна. “ТТТ” ХХК-руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил хийгдэж байна.</p> <p>- Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж 228.8 сая төгрөгөөр “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4 дүгээр хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2022 оны жилийн эцэс)**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	5	24	НЗДТГ-8, НАГ -1, АЕГ -1 НХААГ-1 НССТөв-1, Нийслэл дэх Жендерийн салбар хороо – 1 сургалтад давхардсан тоогоор байгууллагын 107 албан хаагчийг сургалтанд хамруулав
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	7	
			Мэргэшүүлэх сургалт	-	-	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	17	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	107	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	57	
			Эрэгтэй албан хаагч	-	50	
			Удирдах албан тушаалтан	-	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	105	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	Давхардсан тоогоор 107			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	

		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	-	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	-	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	50	Цалин, шагнал, урамшуулал нь жилийн нийт төсөвт эзлэх хувь 55,3 хувь.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Ажилчдын хоол унааны зардалд өдрийн 10000 төгрөгийг тооцож олгодог. 26,4 сая төгрөг төсөвлөгдсөн.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		3 дугаар улиралд
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	2022 оны төсөвт ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах төсөв тусгагдаагүй тул албан хаагчдыг НД-ийн хөнгөлөлтөөр эрт элрүүлэг шинжилгээнд хамрагдах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар 2 албан хаагч бүрэн

						хамрагдаж, шинжилгээний үр дүнгийн дагуу эмчилгээ хийлгэж байна.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	2	
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	1600.0	Тухайн онд ажлын үр бүтээлтэй, хамт олноо манлайлан, зөрчилгүй ажилласанг үнэлэн 2 албан хаагчийг нэг сарын цалингаар шагнаж урамшуулсан.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9 дүгээр хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Эрхэм зорилго, алсын хараа, тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудсанд байршуулсан. Үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын явцыг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
1.2.	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Үйл ажиллагааны чиглэл, бүтэц, холбоо барих, санал хүсэлт, албан хаагчдын мэдээлэл, ажиллах цагийн хуваарийг оруулсан. Захиргааны ажилтан болон Маркетинг, ОНХХ мэргэжилтний нэр, албан тушаал, утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд шинэчлэгдсэн тухай бүрт нь байршуулдаг.	100%
1.3.	эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Газрын даргын хариуцлагын гэрээ, биелэлт, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дотоод хяналт, шалгалтыг гүйцэтгэх комиссын төлөвлөгөө, биелэлт зэргийг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
1.4.	хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж цахим хуудсанд байршуулсан.	100%
1.5.	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	“Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хотын иргэний жил”-ийн хүрээнд тус тус хийгдсэн тайлан, биелэлтүүдийг вэбэд оруулсан.	100%
1.6.	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	2022 оны 07 сард Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан. Мөн бусад хууль тогтоомжуудыг цаг тухай бүрт нь вэб сайтад оруулдаг.	100%

1.7.	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, холбоо барих утас, цахим хаягийг ил тод мэдээлж, өөрчлөгдсөн тухай бүрт нь шинэчлэдэг.	100%
1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Улирал тус бүрээр тогтмол мэдээллэж ажилладаг.	100%
1.9.	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Барилгын салбарын статистик мэдээллийг Барилга хот байгуулалтын яамнаас шууд авах боломжтой холбоосыг цахим хуудсанд оруулж өгсөн.	100%
1.10.	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах тухай бүртээ байгууллагын вэб хуудас болон орон нутгийн мэдээллийн цахим хуудсуудаар мэдээллэж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Сул орон тоо гарсан тухай бүрт нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хөдөлмөр халамжийн хэлтсээр дамжуулан мэдээллэж, орон нутгийн цахим хуудсуудаар мэдээлэл түгээдэг.	100%
2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Ажилтан сонгон шалгаруулах журам, үе шатыг цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд, анкет, албан тушаалын тодорхойлолт, шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрийн тухай мэдээллийг цахим хуудаснаас авах бүрэн боломжтой.	100%
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	2021 оны 01 сарын 22-ны өдрийн А/02 тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүд, дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд байгууллагын цахим хуудсанд өөрчлөгдсөн цаг тухайд нь оруулсан.	100%
2.4.	хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрүүдийг цахим хуудсанд оруулсан.	
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Жил бүр шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээг оруулдаг. Мөн	100%
2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Ур чадварын нэмэгдэл олгох журмыг цахим хуудсанд оруулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Цаг тухай бүрт нь оруулдаг.	100%

3.2.	төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг сар бүр оруулдаг. Хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
3.3.	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Жил бүрийн аудитын дүгнэлт болон зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээллэдэг.	100%
3.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төлбөр хураамж, үйлчилгээний хөлс авдаггүй.	100%
3.5.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Тухайн мэдээллүүдийг шилэн дансанд цаг тухай бүрт нь байршуулдаг бөгөөд байгууллагын вэб сайтнаас шилэн данс руу шууд холбогдох боломжийг бүрдүүлсэн.	100%
3.6.	таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		100%
3.7.	цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		100%
3.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		100%
3.9.	шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		Шилэн дансны мэдээллийг тогтмол, бүрэн гүйцэт оруулдаг.
3.10.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүр цахим хуудсаар мэдээллэдэг. Байгууллагын зүгээс зарласан тендэр байхгүй.	100%

3.11.	худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Шилэн данс	100%
3.12.	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Байхгүй.	100%
3.13.	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Бүтээн байгуулалт болон зураг төслийн ажлын явцын талаарх мэдээллийг тухай бүрт нь байршуулдаг. Мөн улс нийслэлийн төсвөөр хэрэгжүүлж буй ажлуудыг нэгтгэн, оны эцэст мэдээлэл оруулдаг.	100%
3.14.	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Байхгүй.	100%
3.15.	хууль тогтоомжид заасан бусад.	Улс нийслэлийн төсвөөр хийгдсэн ажлуудын явц, хэрэгжилт, мөнгөн дүнг тогтмол мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			
<u>Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал</u>			
4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Хамтран ажиллах хүсэлтэй аж ахуйн нэгж, хувь хүмүүст тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулдаг.	100%
4.2.	тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тусгай зөвшөөрөл олгодоггүй.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
<u>Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал</u>			
5.1.	олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Байхгүй.	100%
5.2.	эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Байхгүй.	100%

5.3.	хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Байхгүй.	100%
5.4.	мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эзэмшиж байгаа 3 газрын гэрээ, гэрчилгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.5.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Байгууллагын нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн үйл ажиллагааны мэдээллүүдийг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
5.6.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Удирдах зөвлөл байхгүй.	100%
5.7.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, тайлан дүгнэлтийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээлж ажилладаг.	100%
5.8.	мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.9.	барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Оффисын барилга, худаг, үерийн байгууламж болон авто замын хүлээн авсан акт, дүгнэлтийг цахим хуудсанд оруулсан.	100%

5.10.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Парк, Парктай гэрээ байгуулсан ААН-үүд хамтарсан гурвалсан гэрээ байгуулсан. Тус гэрээг байгууллагын цахим хуудсанд ил тод мэдээлж ажилласан.	100%
5.11.	нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Байхгүй.	100%
5.12.	мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Байгууллагын зардлаар суралцагсдын мэдээллийг цаг тухай бүрт нь оруулдаг.	100%
5.13.	хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, гадаад хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, уулзалтын үр дүн, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн ажлууд зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүрт нь ил тод мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%

ЗӨВШӨӨРСӨН:

НБМҮТП ОНӨТҮГ-ЫН ДАРГА

С.БАТЖАРГАЛ

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.ПҮРЭВСҮРЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ГАНТУЛГА